



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 351

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын Газрын тусгай үйлчилгээний албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 32,411,833.00 (гучин хоёр сая дөрвөн зуун арван нэгэн мянга найман зуун гучин гурав) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг "Дархан-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын Газрын тусгай үйлчилгээний албаны дарга С.Чинзориг, "Дархан-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Баясгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д оруулан бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
351 дүгээр тогтоолын хавсралт



ИНЕГ-ын харьяа Газрын үйлчилгээний албаны балансаас "Дархан-А33А" ТӨХЖ-ийн балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашинны нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтанд орсон он	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нийт үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	ДУ-16 Г маркийн, улсын дугаар-36-68 УБ, арлын дугаар-000186	1989/1989	Ш	1	3,972,600.00	3,972,600.00	0.00
2	DBL-1AT маркийн, улсын дугаар-14-51 УБХ, арлын дугаар-26539	1998/1998	Ш	1	28,439,233.00	28,439,233.00	0.00
				2	32,411,833.00	32,411,833.00	0.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		2 (хоёр)		32,411,833.00 (гучин хоёр сая дөрвөн зуун арван нэгэн мянга найман зуун гучин гурав)	32,411,833.00 (гучин хоёр сая дөрвөн зуун арван нэгэн мянга найман зуун гучин гурав)	